**2025** он манай баг, хамт олны хувьд үр дүнтэй санал санаачилга гарган, стратегийн түншлэлийг цааш бэхжүүлэн хүмүүсийн амьдралд эерэг үр нөлөөг үргэлжлүүлэн бий болгохын төлөө хичээнгүйлэн ажилласан амжилттай жил байлаа.

Юуны өмнө, санхүүжүүлэгч, мөн дэмжигч байгууллагууд болох бодлогын яамд, шат шатны орон нутгийн засаг захиргааны түншлэгч талууддаа гүнээ талархал илэрхийлье. Төрийн бодлого, Та бүхний стратегитай өөрсдийн үйл ажиллагааг уялдуулахын зэрэгцээ үр дүнтэй шийдлүүдийг хамтран эрэлхийлж илүү сайхан ирээдүйн төлөө бодит үр нөлөө үзүүлэхээр хамтран зүтгэж байгаадаа баяртай байна.

Тухайлбал, Баян-Өлгий аймгийн гурван сумдад нэвтрүүлсэн наран хүлэмжүүд тариалалтын хугацааг 4 сараас 10 сарын сүүл хүртэл уртасгаж хүлэмжээс хоёр удаа ургац хураах боломжийг бий болгосон эерэг үр нөлөө үзүүлэв. Ийнхүү өрхийн тогтвортой орлогын эх үүсвэр, эрүүл хүнсээр хангагдах боломжийг нэмэгдүүлсэн эрс тэрс уур амьсгалд дасан зохицох чадавхтай туршлагыг түгээн ажиллав.

Органик хөдөө аж ахуйг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй манай төсөл нь органик үйлдвэрлэлийг Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудад тэлж, хоршоодын тариалсан органик төмс, хүнсний ногоо, зөгийн балын тогтвортой нийлүүлэлтийн сүлжээг талуудын хамт хөгжүүлэхээр хичээнгүйлэн ажиллаж байна.

Түүнчлэн, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн CELEBRATIONS төсөл нь эрүүл амьдралын дадлыг хэвшүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагаануудыг зохион байгуулж нийт 3,500 гаруй өсвөр үеийнхэн, тэдний эцэг эх, багш, сургуулийн хамт олныг хамруулж, эрүүл дадлыг хэвшүүлэхэд чиглэсэн арга аргачлал, сургалтын хөтөлбөр, мэдээллийг хөгжүүлэв.

Мөн, гурав дах жилдээ хэрэгжүүлж буй нарийн ноост хонины үржлийн төслийн хүрээнд зохиомол хээлтүүлгийг төрийн мэргэжлийн, судалгааны мөн орон нутгийн малын эмч, малчидтай хамтран сумын түвшинд зохион байгуулснаар зохиомол хээлтүүлгийн тоо, хамрах хүрээг тэлж, нарийн ноост хонины үүлдэр угсааг сайжруулахад томоохон ахиц гаргалаа.

Хүмүүсийн амьдралд эерэг өөрчлөлтийг бий болгохын төлөө хамтран ажилласан түншлэгч талууд, санхүүжүүлэгчдэдээ бид чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье.

Эцэст нь, Бурханы хүслийн дагуу урт хугацааны тогтвортой сайн сайхан үр нөлөөг бий болгоход бид үйл ажиллагаагаа чиглүүлэн тууштай ажиллах болно.



Хүндэтгэсэн,

**ВИНДЕЛЛ М. МАРАНАН**  
Суурин төлөөлөгч



## АДРА ОУБ-ын танилцуулга

Адвентист Хөгжил Туслалцааны Агентлаг (АДРА) нь 1956 онд Долоо дахь өдрийн Адвентист сүмийн үүсгэн байгуулсан, бие даасан хүмүүнлэгийн байгууллага юм. АДРА нь хөгжиж буй орнууд дахь нийгмийн шударга бус байдал, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж шийдвэрлэх, тусламж хэрэгтэй иргэдийн амьдралын чанарыг сайжруулахын төлөө ажилладаг. АДРА нь дэлхийн 120 гаруй улсад төлөөлөгчийн газартай бөгөөд тэдгээрийн нэг нь АДРА Монгол билээ.

АДРА Монгол ОУБ нь Монгол улсад 1994 оноос үйл ажиллагаагаа эхлүүлэн, өнгөрсөн 32 жилийн турш иргэд, орон нутаг, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, Монголчуудын амьдралын чанарыг сайжруулахын төлөө хүнсний аюулгүй байдал, иргэдийн амьжиргаа/эдийн засгийн хөгжил, эрүүл мэнд, боловсрол, гамшгийн эрсдэлийг бууруулах таван бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлсээр ирсэн.

Өнөөдрийн байдлаар, АДРА дээрх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд нийт 197 төсөл хэрэгжүүлээд байна. Нийт зарцуулсан санхүүжилтийн хэмжээ ойролцоогоор 34,591,299 сая ам.долларт хүрсэн бөгөөд нэг жилд дунджаар 1,080,978 сая ам.доллар зарцуулжээ.

## Алсын хараа

АДРА Монгол ОУБ нь мэргэшсэн, шинийг эрэлхийлэгч, тасралтгүй суралцагч, үр дүнтэй үйл ажиллагаа бүхий нэгдсэн, шударга, ил тод байдлыг хангасан олон улсын сүлжээ байгууллагад харьяалагддаг. АДРА нь орон зай, хил хязгаарыг үл харгалзан нийгмийн эрсдэлт болон дэмжлэг нэн шаардлагатай бүлгийн хүмүүсийг чадавхжуулан тэдний дуу хоолойг өргөн, тэдний амьдралд хэмжигдэхүйц, бодит, тогтвортой өөрчлөлтүүдийг авчрахын төлөө ажилладаг.



## Мөн чанар

Адвентист Хөгжил Туслалцааны Агентлаг нь Бурханы хайр энэрлийг үзүүлдэг Долоо дахь өдрийн Адвентист сүмийн байгуулсан, даян дэлхийн хүмүүнлэгийн байгууллага юм.

## Эрхэм зорилго

Хүн төрөлхтнийг Бурханы хүслийн дагуу сайн сайхан амьдрахад туслах.

## Төсөл хэрэгжиж буй газрууд



# Тэргүүлэх чиглэлүүд



## ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

Шаргуу хөдөлмөр нь ядуурлын мөчлөгийг тасалдаг. АДРА нь гэр бүл, олон нийтийг бэхжүүлэх зорилготойгоор эмзэг бүлгийн иргэдэд бага хэмжээний зээл, мэргэжлийн сургалт, дэмжлэгийн тогтолцоог үзүүлдэг.



## ЭРҮҮЛ МЭНД

Бид эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулж, амьдралын хэв маягийг сайжруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ нярай болон гэр бүлийн дэмжлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн зөвлөгөө болон олон нийтэд суурилсан эрүүл мэндийн бусад тогтолцоог хөгжүүлдэг.



## БОЛОВСРОЛ

Хүүхэд бүр эрүүл, аюулгүй орчинд өсөж хөгжих боломжийг хүртэх эрхтэй. Бидний үзүүлдэг үндсэн хэрэгцээнүүд болох хоол хүнс, цэвэр ус, эрүүл мэндийн үйлчилгээ, боловсрол нь хүүхдүүдийг хүүхэд насандаа төвлөрч, ирээдүйдээ итгэлтэй байх боломжийг олгодог.



## НӨЛӨӨЛӨЛ

АДРА нь нийгмийн эмзэг бүлгүүд рүү чиглэн ажиллаж, олон нийтийг өөрсдийн чадавхыг бүрэн ашиглаж, нийгэмд эрх тэгш оролцон амьдрахад нь дэмжлэг үзүүлдэг.



## ГАМШГИЙН МЕНЕЖМЕНТ

Дайн, хар салхи, ган гачиг, үер, зуд, газар хөдлөлт зэрэг гамшигт нөхцөл байдал тохиолдоход олон хүн орон гэргүй, амьжиргаагүй эх үүсвэрээ алддаг. АДРА нь орон нутгийн засаг захиргаатай хамтран гамшигт өртсөн хүмүүст яаралтай эмнэлгийн тусламж, хоол хүнс, ус, орогнох байр, мөн бэлэн мөнгөний тусламж олгодог.



## ХӨДӨӨ АЖ АХУЙ

Мал аж ахуй эсвэл газар тариалангийн сургалт авах нь гэр бүлийн хоол хүнсийг хангахаас гадна орлого болон хуримтлал бий болгохын тулд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулах боломжийг бүрдүүлдэг.

2025 онд АДРА Монгол ОУБ нь хүнсний аюулгүй байдал, амьжиргаа, эрүүл мэнд, гамшгийн менежмент, боловсрол гэсэн таван салбарын хүрээнд стратегийн түншлэл, төсөл хөтөлбөрүүдээр дамжуулан нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд дэмжлэг үзүүлж, чадавх бэхжүүлэх зорилгодоо хүрэхээр зорин ажиллав.

Баян-Өлгий аймагт нарлаг хүлэмж ашиглан эрс тэс уур амьсгалд нийцсэн газар тариалангийн шинэлэг аргыг нэвтрүүлж буй төслийн 2 дугаар жил амжилттай хэрэгжиж, төсөлд хамрагдсан тариаланч өрхүүд төрөл бүрийн ногоо тариалж, ургамал ургалтын хугацааг 4-р сараас 10-р сарын эцэс хүртэл уртасгалаа.

Мөн нарийн болон нарийвтар ноост хонины үүлдэр угсааг сайжруулахад чиглэсэн төслийн 3 дугаар шатанд малчид аж ахуйн нэгжүүдийн хонио зохиомол хээлтүүлэгт хамруулах сонирхол нэмэгдэж 23 өрхөөс 29 өрх, 680 толгой хониноос 1,052 болж өссөн. Төслийн зүгээс зохион байгуулсан хонь хяргалтын сургалтад хамрагдсан оролцогч Улсын хэмжээнд зохион байгуулагдсан хонь хяргалтын тэмцээнд оролцон 2 дугаар байр эзэлснээс гадна Шинэ Зеланд улс руу хяргагчаар ажиллахаар болсон.

Манай органик хөдөө аж ахуйн төсөл нь Сэлэнгэ болон Дархан-Уул аймгуудын тариаланчдын үйлдвэрлэл, зах зээлд нэвтрэх боломжийг өөрчилж, шинэ шатанд гаргахаар зорьж байгаа билээ. Бид хоршоодыг чадавхжуулах ажлын хүрээнд органик хөдөө аж ахуйн мэдлэг, органик тариалангийн дадлыг чадавхжуулах, ургамлын өвчлөл, хортон шавж, хог ургамалтай хэрхэн тэмцэх зэрэг 14 удаагийн сургалт, зөвлөх үйлчилгээг давхардсан тоогоор 1,298 хоршооны гишүүнийг хамруулан зохион байгуулсан. Үүний үр дүнд органик газар тариалангийн чиглэлээр шинээр 101 гишүүн органик үйлдвэрлэлд шилжиж, тангараг өргөсөн. Мөн хамтын баталгаажуулалтын байгууллагын 269 гишүүний 524 бүтээгдэхүүн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны органик хүнсний бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдэж эхэлж, албан ёсны мэдэгдэл, органик лого хэрэглэх эрх авах ажил хийгдэж байна. Мөн төслийн хүрээнд Улаанбаатар хотод органик бүтээгдэхүүн борлуулалтын цэгүүдийг байгуулж, органик үйлдвэрлэгчдийг хотын хэрэглэгчидтэй шууд холбон ажиллаж байна.

2025 онд халдварт бус өвчнөөс сэргийлэх төслийн хүрээнд өсвөр насны хүүхдүүдийн дунд эрүүл амьдралын дадал, хэв маягийн талаарх ойлголтыг нэмэгдүүлж, сургуулийн болон гэр бүлийн орчинд сурсан мэдсэн зүйлсээ хуваалцахыг уриалан ажиллан олон нийт болон засаг захиргааны нэгжүүдтэй хамтын ажиллагаагаа бататгаж, сургуулиудын дотоод журам, бодлогуудад эрүүл далдын талаарх зүйлүүдийг тусгахад нөлөөлсөн билээ. Ингэснээр, Монголын өсвөр үеийнхэнд эрүүл, идэвхтэй амьдралын дадлуудыг төлөвшүүлэхэд чухал хувь нэмэр орууллаа.

Эцэст нь бид нийгмийн нэн шаардлагатай бүлэгт өвлийн дулаан гутал олгох “Дэм дэмэндээ” төслийн хүрээнд Хан-Уул дүүргийн 12-р хороонд байрлах Нийслэлийн ерөнхий боловсролын 10-р сургуулийн 6-16 нас хүртэлх сурагчдад хүрч ажиллалаа.

## 1,052

хонинд Австралийн Мерино үүлдрийн гүн хөлдөөсөн үрийг ашиглан зохиомол хээлтүүлэг хийж нарийн ноост хонины үржлийн чанарыг сайжруулсан.

## 2,890

сурагч, багш, эцэг эхчүүд сэтгэцийн эрүүл мэнд, биеийн идэвхтэй хөдөлгөөн, архи тамхинаас татгалзах сэдвүүдэд чиглэсэн эрүүл мэндийн аянд оролцсон.

## 690

тариаланч эрс тэс уур амьсгалтай бүс нутагт наран хүлэмжийн тариалалтыг нэвтрүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг хүлээн авсан.

## 51,800

килограмм улаан буудайн хивэг, нэмэлт эрдсийн шахмалын хамтаар зохиомол хээлтүүлэгт хонио хамруулсан өрхүүдэд нийлүүлсэн.

## 4,661

килограмм органик зөгийн бал хураан авч, 3 тонн гаруй хүнсний ногоо тариалж зах зээлд нийлүүлсэн.

## 552

хамтын баталгаажуулалтын байгууллагын 552 бүтээгдэхүүн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны органик хүнсний бүртгэлд бүртгэгдсэн.

## 108,456

килограмм хүнсний ногоог 150 өрх Баян-Өлгий аймгийн эрс тэс уур амьсгалд тариалж, зах зээлд нийлүүлсэн.

## 1,298

(давхардсан тоогоор) хоршооны гишүүд органик тариалангийн дадлыг чадавхжуулах сургалтад хамрагдсан.



## Эрс тэс уур амьсгалд нийцсэн газар тариалан төсөл

### Төслийн мэдээлэл

Хугацаа	2024 оны 4 сар - 2027 оны 3 сар
Зорилтот бүс	Баян-Өлгий аймгийн Өлгий, Бугат, Сагсай сумд
Зорилтот бүлэг	225 өрх (48,000 шууд бус)
Нийт төсөв	340,000.00 ам.доллар

Төслийг АДРА Япон, АДРА Герман болон АДРА ХонгКонг санхүүжүүлэв.



2025 оны 4-р сард төслийн баг төслийн хоёр дахь жилийн 75 оролцогч өрхийг сонгож, нийт 150 өрхтэй хамтран ажиллаж, газар тариалангийн сургалтууд зохион байгууллаа. Мөн газар тариалан хамт эрхлэн бие биеэсээ суралцаж, бие биеэ дэмжин ажиллах газар тариалангийн 5 бүлэг шинээр нэмж үүсгэсэн. 2025 оны 5-р сараас 10-р сарын дунд хүртэл төслийн агрономич А.Гаухар нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох газар тариалангийн аргад таван сургагч багш (ТОТ) шинээр сургаж бэлтгэн тэдэнтэй хамтран бусад оролцогчдод зориулсан сургалтуудыг зохион байгууллаа.

Эдгээр сургагч багш нар нь газар тариалангийн шинэлэг аргуудыг онол дадлагатай хослуулан суралцаж цогц мэдлэг эзэмшлээ.

Төслийн баг бүх сургалтыг орон нутгийн хүн амын онцлогоос шалтгаалан монгол, казах хэл дээр зохион байгуулдаг ба гарын авлага болон тараах материалуудыг хоёр хэл дээр хэвлэн нийт 75 оролцогчид тарааж олгосноор өдөр тутмын үйл ажиллагаандаа үр дүнтэй хэрэглэх боломжтой болсон.

2025 оны 7-р сарын 22-ноос 29-ний хооронд Баян-Өлгий аймгийн зорилтот сумдад хэрэгжиж буй төслийн үйл ажиллагаатай танилцан хяналт үнэлгээ хийх зорилгоор Суурин төлөөлөгч Виндел Маранан ажлын айлчлал хийлээ. Айлчлалын хүрээнд наран хүлэмжийн өмнөх жилийн ахиц дэвшлийн үнэлгээ, төслийн багийнхантай хийсэн эргэцүүлэл, дүгнэлт уулзалт болон төслийн нөхцөл байдлын талаар цогц ойлголттой болохын тулд орон нутгийн соёл, байгаль орчинтой танилцах зэрэг ажлууд хийгдлээ.



2025 онд нийт 50 идэвхгүй нарны хүлэмжийг амжилттай барьж бүрэн ашиглалтад орууллаа. Тариаланч өрхүүд төрөл бүрийн хүнсний ногоо тариалж, ургамал ургалтын хугацааг 4-р сараас 10-р сарын сүүл хүртэл уртасгалаа. Мөн түүнчлэн нийт 150 өрхөд 1200 үрийн багц, 450 гар багажийг тарааж, 10 өрхийн гэр зоорь барих ажлыг дэмжиж шинэхэн болон даршилсан бүтээгдэхүүнийг жилийн турш аюулгүй хадгалах боломжийг олгосон. Эдгээр арга хэмжээ нь тогтвортой газар тариалан эрхлэхэд үр дүнгээ өгч тариаланчдын хугацааг уртасгах боломжтой болгосноос гадна өрхүүдэд хүлэмжээс хоёр удаа ургац хураах боломжийг бий болгосон. Мөн тариаланч өрхүүдийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулж, хүнсний ногооноос олох орлогыг нэмэгдүүлсэн байна. 2025 онд нийт оролцогч 150 өрх 20,426 м<sup>2</sup> талбайд тариалж 108,456 кг хүнсний ногоо хурааж, нийт 388,321,650 төгрөгийн орлого буюу өрх бүр дунджаар 2,588,811 төгрөгийн орлого олсон байна.



Тариалан эрхэлдэг өрхүүдэд тулгардаг гол бэрхшээлүүдийн нэг бол гэрийнхээ эрүүл хүнсний ногоог чанарын хувьд алдагдуулахгүйгээр урт хугацаанд ахуйн хэрэгцээнд зориулан хадгалах явдал юм. Үүнийг шийдвэрлэхийн тулд төслийн баг гэр зоорь барих тусгай сургалтыг 10 сургагч багш нарт зохион байгууллаа. Сургалтаар авсан мэдлэг дээрээ үндэслэн гэр зоорь барих ажлыг зохион байгуулж нийт зардлын 50 хувийн дэмжлэг төслөөс үзүүлсэн ба энэ жил дахин 5 өрх зоорио амжилттай барьж ашиглалтад орууллаа. Тус бүр нь ойролцоогоор 4 м<sup>2</sup> хэмжээтэй бөгөөд тухайн өрхийн хүнсний ногооны гарц, жилийн турш хадгалах шаардлагад үндэслэн боловсруулсан. Эдгээр зоорь нь шинэхэн болон даршилсан бүтээгдэхүүнийг хоёулыг нь хадгалдаг бөгөөд энэ нь улирлын бус үед ч гэсэн гэр бүлүүдэд тэжээллэг хоол хүнс авах боломжийг олгодог.

“Өмнө нь би хашаандаа ногоо тарина гэж огт төсөөлж байгаагүй.”



## Амжилтын түүх

Тэр бол Өлгий хотын оршин суугч Х.Багдаулет. Тэрбээр өөрийн хашаандаа ногоо тарина гэж төсөөлж ч байгаагүй нэгэн билээ. Хурдан дуусах зуны өдрүүд, удаан үргэлжлэх өвөл болдог Баян-Өлгий аймгийн эрс тэс уур амьсгалтай орчинд хүнсний ногоо тариалах нь боломжгүй мэт санагдсан. Нутгийнхаа олон залуусын нэгэн адил тэрээр газар тариалангийн талаар туршлагагүй байв.


2024 онд төсөлд хамрагдаж буй хадам аав нь түүнийг Өлгий дэх АДРА-гийн оффис дээр очихыг уриалснаар бүх зүйл өөрчлөгдсөн. Ийнхүү Багдаулет наран хүлэмжийн шинэлэг технологийн талаар олж мэдсэн.

Багдаулет төслийн зүгээс явуулсан сургалтад хамрагдаж анхны наран хүлэмжээ барьж, гайхалтай үр дүнд хүрсэн: тэрээр 6-р сарын дунд үеэс байцаа, өргөст хэмх хурааж эхэлсэн бөгөөд өмнөх жилтэй харьцуулахад орлогоо хоёр дахин нэмэгдүүлсэн, одоо аймгийн төвийн ресторонуудыг чанартай, эрүүл ногоогоор хангаж байна. Түүний эхнэр төслөөс зохион байгуулсан хоол тэжээлийн сургалтад хамрагдсан бөгөөд одоо өөрсдийн тарьж ургуулсан хүнсний ногоогоор төрөл бүрийн хоол бэлдэж, гэр бүлийнхээ эрүүл хооллох дадлыг бий болгож байна.

“Өмнө нь би хашаандаа ногоо тарина гэж огт төсөөлж байгаагүй. Энэ нь боломжгүй юм шиг санагдаж байсан ч одоо миний харах өнцөг бүрмөсөн өөрчлөгдөж, амжилт гаргасандаа баярлаж байна” - Багдаулет

Өнөөдөр тэрээр арваннэгдүгээр сар хүртэл ургац хураахаар төлөвлөж, найз нөхөд, хөршүүд, залуучуудыг ногоо тарихыг идэвхтэй уриалж байна.





## Органик хөдөө аж ахуйн түншлэл-2 төсөл

### Төслийн мэдээлэл

Хугацаа	2023 оны 10 сар - 2026 оны 12 сар
Зорилтот бүс	Сэлэнгэ, Дархан-Уул аймгууд
Зорилтот бүлэг	Сэлэнгэ аймгийн 31 хоршоо, Дархан-Уул аймгийн 10 хоршоо
Нийт төсөв	1,852,830 ам.доллар

Төслийг ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам болон АДРА Герман санхүүжүүлэв.

зөвлөх үйлчилгээг давхардсан тоогоор 1298 хоршооны гишүүнийг 2025 оны 12 дугаар сарын байдлаар хамруулан зохион байгуулсан.

Мөн Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн томоохон 7 гол, худаг, шуудуу зэрэгт усны чанарын үнэлгээ хийх, төслөөс боловсруулсан гарын авлага, бордоо, фитоспорины бэлдмэл зэргийг тараасан болно. Түүнчлэн органик үйлдвэрлэлийг дэмжиж органикийн стандарт шаардлагыг хангасан үр, бордоо, хөдөлмөр хөнгөвчилсөн багаж, жижиг тоног төхөөрөмж, хүлэмжийн дэмжлэгийг 2025 онд 15 хоршоонд үзүүлснээр төсөл эхэлснээс хойш төслийн үр шим хүртэгч бүх 40 анхан шатны хоршоонд тус дэмжлэгийг олгосон байна. Түүнчлэн Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол, Дархан-Уул аймгийн Хонгор, Орхон сумуудад гурван улирлын хүлэмжийг барьж хүлээлгэн өгсөн.

Органик газар тариалангийн чиглэлээр шинээр 101 гишүүн органик үйлдвэрлэлд шилжиж, тангараг өргөсөн. Мөн хамтын баталгаажуулалтын байгууллагын 269 гишүүний 524 бүтээгдэхүүн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны (ХХААХҮЯ) органик хүнсний бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдэж эхэлж, албан ёсны мэдэгдэл, органик лого хэрэглэх эрх авах ажил хийгдэж байна. Ийнхүү 2025 онд нийт 57 га-д 35 нэр төрлийн төмс, хүнсний ногоо тариалж, мөн органик зөгийн балыг хураан авч зах зээлд нийлүүлж байна.

Газар тариалангийн бус улиралд эрхлэх бизнесийн үйл ажиллагааг тэлэх зорилгоор 2025 оны байдлаар нийт 40 хоршоонд оёдол, эсгий, мужаан, сүү, мах, даршилсан нөөшилсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бага оврын тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө. Мөн 15 нэмүү өртөг шингэсэн органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажлын байр, 12 улирлын бус бизнесийн үйл ажиллагаа явуулах ажлын байруудыг засах дэмжлэг үзүүлсэн. Шилжилтийн үеийн 9 нэмүү өртөг шингэсэн органик бүтээгдэхүүнийг баталгаажуулж ХХААХҮЯ-ны органик хүнсний бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлсэн.

Сэлэнгийн органик, Дархан органик үйлдвэрлэгчид органик хүнсний ногоо, зөгийн бал, өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг Сэлэнгэ таван хайрхан дундын хоршоогоор дамжуулан үйлдвэрлэгчээс хэрэглэгчдэд шууд хүргэх зорилгоор Улаанбаатар хотод органик бүтээгдэхүүний дэлгүүр, лангууг төслийн дэмжлэгтэйгээр ажиллуулж, тэдгээрийн борлуулалтад дэмжлэг үзүүлэн ажиллахаас гадна сургууль, цэцэрлэг, уул уурхайн үйлдвэр, эмнэлгийн байгууллага зэрэгтэй борлуулалт, нийлүүлэлтийн гэрээ байгуулахаар ажиллаж байна.



Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн эрх зүйн орчин, цаашдын зорилтыг тодорхойлох, Сэлэнгэ, Дархан-Уул аймгаас нийлүүлдэг органик хүнсний нийлүүлэлт, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх, агуулахын асуудлыг шийдвэрлэх, оролцогч талуудын үр ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн орон нутгийн, бүсийн болон үндэсний хэмжээний нийт 12 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөний хүрээнд Монголын Хөдөө Аж Ахуйн Хоршоологчдын Үндэсний Холбоотой санамж бичиг байгуулж, мөн анхан шатны хоршоодын гишүүдийн Үндэсний органикийн холбоог "Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх түншлэл үндэсний холбоо" нэрээр бүртгүүлж, байгуулснаар анхны хурлаа хийн хүнсний ногооны зах зээл, нийлүүлэлтийн сүлжээ, нэгдсэн хүнсний ногооны агуулах, органик хүнсний бүртгэлийн асуудал зэрэг тулгамдаж буй чиглэлүүдээр хамтран ажиллаж байна.



## Бүргэдэйн Өнөр Булаг

- Манлайлал болсон органик хоршоо



## Амжилтын түүх

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын “Бүргэдэйн Өнөр Булаг” хоршоо нь органик хөдөө аж ахуйг хөгжүүлэх, гишүүдийнхээ орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр олон санаачилгыг амжилттай хэрэгжүүлж буй үлгэр жишээ байгууллага юм.

Ихэвчлэн органик хулуу, навчит ногоо тариалдаг А.Эрдэнэчимэг нь “Бүргэдэйн Өнөр Булаг” хоршооны менежерээр ажилладаг. Тус хоршооны гишүүд Хүнс Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамны органик бүтээгдэхүүний бүртгэл мэдээллийн санд бүтээгдэхүүнээ органикаар бүртгүүлж, “Органик тариаланч” хэмээх хүндтэй гэрчилгээ хүртсэн “анхдагчийн” нэг юм.

А.Эрдэнэчимэг нь органик хүнсний ногоо тариалахад шаардлагатай ус, хөрсний шинжилгээ хийх, ургамлын хортон шавж болон өвчнийг органик аргаар таньж, тэмцэх мэдлэгийг эзэмшиж, хөрс хамгааллын аргачлалд мэргэшин суралцжээ. Түүнчлэн газар тариалангийн улирлын бус үед нэмэлт орлоготой болох зорилгоор хоршооны гишүүдтэйгээ хамтран бүтээгдэхүүн боловсруулах сургалт, тоног төхөөрөмжийн дэмжлэг авч, үйлдвэрлэлээ эхлүүлсэн нь тэдний амьдралд бодит үр дүн авчирч буйг дурдсан юм.

Мөн хоршооны гишүүд хэдийгээр гавьяаныхаа амралтад гарсан ч үргэлжлүүлэн суралцаж, өөрсдийгөө хөгжүүлсээр байна. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Политехник коллежийн мод үржүүлгийн сургалтад хамрагдан “мэргэжилтэн” болж, модны үрсэлгээгээ зах зээлд гаргахыг оролдсон ч амжилт багатай байжээ. Үүний дараа тэд зөгий үржүүлгийн чиглэлээр мөн туршсан боловч хүссэн үр дүндээ хүрээгүй байна. Гэсэн ч шантралгүй, эв нэгдэлтэйгээр дахин шинэ санаа сэдэж, дараагийн алхмаа төлөвлөжээ.

Ингээд хоршооны гишүүдтэйгээ хамтран өөрсдийн органик хүнсээр хоол хийх ур чадвар эзэмших зорилгоор мэргэжлийн тогоочийн ангид суралцах хүсэлт гаргасан нь сумын Засаг дарга болон Сэлэнгэ аймгийн политехник коллежоос дэмжлэг авч, 20 хүний бүрэлдэхүүнтэй анги байгуулагдахад хүргэсэн юм.

Тус сургалтыг амжилттай дүүргэсэн хоршооны гишүүд өдгөө сургуулийн цайны газрыг ажиллуулан өөрсдийн тарьсан органик хүнсний ногоогоор эрүүл, амт чанартай хоолоор үйлчилж байна. Өнөөдөр “Бүргэдэйн Өнөр Булаг” хоршооны бүх гишүүд өөрийн гэсэн нэмэлт орлоготой болжээ. Цаашид хоршооны гишүүд Сэлэнгэ аймгийн Политехник коллежийн хоёр хүлэмжид органик нарийн ногоо тариалж, ирээдүйн органик тариаланчдыг бэлтгэх ажлыг эхлүүлжээ. Энэ хавар тэд коллежийн хоёр мэргэжлийн ангийн сурагчдад өөрсдийн органик тариалан эрхлэх туршлагаа хуваалцан, өөрсдийн органик тариалангийн талбайд дадлага хийлгэх төлөвлөгөөтэй байна.

“Бид эвтэй байхдаа хүчтэй” хэмээх итгэл үнэмшлээр урагшилсан энэ түүх бол хамтын хүчээр хэрхэн бүтээлч, тогтвортой ирээдүйг бий болгож болдгийг харуулсан бодит жишээ юм.



## Халдварт бус өвчнөөс сэргийлэх төсөл

Төслийн мэдээлэл	
Хугацаа	2023 оны 6 сар - 2026 оны 5 сар
Зорилтот бүс	Улаанбаатар хотын Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх, Налайх дүүргүүд
Зорилтот бүлэг	2000 өсвөр үеийнхэн 2000 эцэг эх/асран хамгаалагч
Нийт төсөв	510,000.00 ам.доллар
Төслийг АДРА Интернэйшнэл, Долоо дахь Өдрийн Адвентист Сүмийн Ерөнхий Чуулган, АДРА ХонгКонг болон АДРА Австри санхүүжүүлэв.	

NextGen CELEBRATIONS! Mongolia төсөл нь 2025 онд Өөдрөг үзэл, Дасгал хөдөлгөөн, Тэсвэр тэвчээр (архи, тамхинаас татгалзах) сэдвүүдийн хүрээнд олон төрлийн үйл ажиллагааг SETONS эрүүл амьдралын дадлуудын зарчимд нийцүүлэн хэрэгжүүлсэн.

Төслийн хүрээнд сурагчдыг идэвхтэй оролцож, эдгээр сэдвүүдийг гүнзгийрүүлэн судалж, ач холбогдлыг нь ойлгохын сацуу өөрсдийн өдөр тутмын амьдралд хэвшүүлэхийг уриалсан.

Сэдэв	Гол арга хэмжээ	Оролцсон сурагчид
Өөдрөг үзэл	Мэдэрэмжээ share-лэг! аян, Талархлын мод, Inside Out кино хэлэлцүүлэг, өдрийн тэмдэглэл, эерэг бататгал үгс	435
Дасгал хөдөлгөөн	9 интерактив хичээл, теннисний ширээ байрлуулж Өдөрт 60 минут дасгал хийх аян	258
Тэсвэр тэвчээр	Электрон тамхины хор ургшийн талаарх мэдлэг олгох, гэр бүлийнхээ орчинд сурч мэдсэн зүйлээ хуваалцах	200+



Төслийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Налайх дүүргийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, төслийн зарчим, арга барилыг дүүргийн Эрүүл мэндийн газрын урт хугацааны стратегид нэвтрүүлэхийг уриалсан. Уулзалтад АНУ-ын Калифорни муж дахь Лома Линда их сургуулийн төлөөлөл, Налайх дүүргийн засаг дарга болон Иргэдин төлөөлөгчдийн хурлын дарга нар оролцов.

2025 онд хэрэгжүүлсэн гол үйл явдлуудаас дурдвал, Дэлхийн тамхины эсрэг өдрийг тохиолдуулан Налайх дүүрэгт 300 орчим сурагч, эцэг эх, багш нарыг хамруулсан парад алхалт зохион байгуулсан. Өдөр тутмын дасгал хөдөлгөөнийг хэвшүүлэхийн тулд Эрдмийн Оргил сургуулийн дотуур байрны сурагчдын дунд ширээний теннисний тэмцээн зохион байгуулсан. Мөн 2024 оны Парисын Олимпын мөнгөн медальт Б. Баасанхүүтэй хамтран хүүхдүүдэд дасгал хөдөлгөөн хийхийн ач холбогдлыг ойлгуулж, урам зориг өгөв.



Төслийн суурь болон дунд шатны судалгааны үр дүнг хамтрагч байгууллагын төлөөлөгчдөд танилцуулав. 771 сурагч, сургуулийн 107 ажилтан, болон 99 эцэг эхийн оролцсон судалгааны үр дүнгээс харахад халдварт бус өвчний талаарх мэдлэгийн түвшин 47% болж, зорилтот 50%-д хүрэхэд ойрхон байна. Сургуулиудад өдөр бүр жимс, ногоо хэрэглэх, сэтгэцийн эрүүл мэндийн өдрийг тэмдэглэх, дасгал хөдөлгөөн хийх завсарлагааны цагтай болгох дотоод дүрэм журмыг батлахад дэмжлэг үзүүлсэн.



## Амжилтын түүх

“Намайг Ану гэдэг, би Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 84-р сургуульд суралцдаг. Өнгөрсөн есдүгээр сараас эхлэн би АДРА ОУБ-ын эрүүл мэндийн төслөөс хэрэгжүүлж байгаа эрүүл мэндийн клубт хамрагдаад явж байна.

Эрүүл мэндийн клубт хамрагдсанаар би ямар хоол хүнснээс татгалзах, мөн ямар хоол хүнс миний эрүүл мэндэд тустай болохыг мэдэж авсан. Жишээлбэл, би өдөр бүр уудаг ундаандаа хэчнээн их сахар агуулагддагийг, эсвэл хэт их боловсруулсан хүнс хэрэглэх нь хожим ноцтой эрүүл мэндийн асуудал үүсгэж болдгийг өмнө нь ойлгодоггүй байсан. Мөн өдөр бүр таван нэгж жимс, ногоо хэрэглэх, дасгал хөдөлгөөн хийх нь эрүүл байхад маш чухал үүрэгтэй гэдгийг ойлгосон.

Клубийн нэг хэсэг болсны дараагаар би өөрийнхөө нэг хэсгийг нээж олж байгаа мэт санагдсан. Одоо би чипсний оронд сургууль руугаа жимс авч явдаг болсон, илүү их ус уудаг болсон, бүр найзуудыгаа өглөө надтай хамт дасгал хийхэд уриалж чадсан. Ийнхүү эрүүл мэнддээ анхаарч байгаагаараа бахархаж байна.”

Түүний сэтгэгдлээс авч үзвэл өсвөр үеийн хүүхдүүдэд эрүүл амьдралын мэдлэг, дадлыг эзэмшүүлснээр хэрхэн халдварт бус өвчний эрсдэлийг бууруулах боломжтой болохыг харж байгаа билээ. Энэхүү төслөөр бид урьдчилан сэргийлэх арга зам дээр хөрөнгө оруулж, залуу хүмүүст мэдээлэлд суурилсан зөв сонголт хийхэд нь дэмжлэг үзүүлж, ирэх олон жилийн турш эрүүл мэндээ хамгаалах боломжийг олгож байна.





## Нарийн, нарийвтар ноост хонь үржүүлгийн төсөл

### Төслийн мэдээлэл

<b>Хугацаа</b>	2025 оны 7 сар - 2026 оны 6 сар
<b>Зорилтот бүс</b>	Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Орхон, Сайхан, Ерөө сум Хэнтий аймгийн Хэрлэн сум
<b>Зорилтот бүлэг</b>	МУСҮТ-ийн мэргэжилтнүүд, 29 малчин өрх, орон нутагт нарийн, нарийвтар ноост хонь үржүүлж байгаа 3 компани
<b>Нийт төсөв</b>	63,588 ам.доллар

Төслийг Монгол дахь Австралийн Элчин Сайдын Яам, Австралийн Милдура Ротари клуб санхүүжүүлэв.

Төслийн I-р үе шатанд Монголын нарийн, нарийвтар ноост хонины чанарыг сайжруулах зорилгоор Австралийн мерино үүлдрийн гүн хөлдөөсөн үр болон хөврөлийг импортлон оруулж ирсэн.

II-р үе шатанд орон нутагт байгаа нарийн нарийвтар ноост хонь үржүүлэгчид, малчдын 630, МААЭШХ-ийн 50 /нийт 680/ нарийн, нарийвтар ноост хонинд Австралиас импортлосон гүн хөлдөөсөн үрийг ашиглан дурангийн аргаар хээлтүүлэг хийсэн.

III үе шатанд хамрагдах хонины тоог нэмэгдүүлэн орон нутагт явуулын лабораторийн нөхцөлд нийт 1052 хонинд амжилттай хээлтүүлэг хийсэн.



2025 он төслийн хувьд Монголын нарийн ноост хонины генетикийг сайжруулах, орон нутгийн малчдыг сургах чиглэлээр ихээхэн ахиц дэвшил гаргасан жил байлаа. Гурван сумын хэмжээнд хэрэгжүүлсэн зохиомол хээлтүүлэгт орсон 1052 хониноос 27 малчин өрх амжилттайгаар хурга өсгөн бойжуулж байна.

Монголын нарийвтар ноост Ерөө, Талын цагаан үүлдрийн хонь үржүүлэгчид төсөлд албан ёсоор хүсэлт гаргасны дагуу Австрали улсаас импортлосон гүн хөлдөөсөн үрийг дээрх 2 үүлдэрт ашиглахаар болсон. Үүнтэй холбоотой Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 50 Ерөө үүлдрийн, Хэнтий аймгийн Хэрлэн сумын цөм сүргийн аж ахуйд 100 Талын цагаан үүлдрийн хонь тус тус хамрагдахаар болсон. Ингэснээр Монгол Улсын хэмжээнд нарийн, нарийвтар ноост хонины үүлдрээр батлагдсан бүх 4 үүлдрийн хонинд Австралийн үүлдрийн үрийг сайжруулагчаар ашиглахаар болсон.



Зохиомол хээлтүүлэгт хамрагдсан эм хониноос ноосны дээж авч микрон болон гарцыг лабораторийн нөхцөлд шинжилж байгаа.

Төслийн зүгээс зохион байгуулсан хонь хяргалтын сургалтад хамрагдсан оролцогч Улсын хэмжээнд зохион байгуулагдсан хонь хяргалтын тэмцээнд оролцон 2 дугаар байр эзэлснээс гадна 1 өдрийн 274 хонь хяргасан амжилт үзүүлж Шинэ Зеланд улс руу хяргагчаар ажиллахаар болсон.

Малчид, АА нэгжүүдийн хонио зохиомол хээлтүүлэгт хамруулах сонирхол нэмэгдэж 23 өрхөөс 29 өрх, 680 толгой хониноос 1052 болж өссөн.

Зохиомол хээлтүүлэгт хонио хамруулсан 27 өрхийн 50%-ийн хөнгөлөлттэйгөөр 51.8 тонн улаан буудайн хивэг, нэмэлт 1264 кг эрдсийн шахмал нийлүүлсэн.



## Онцлох ажлууд



төсөл хэрэгжиж эхэлснээс хойш 2384 хонинд зохиомол хээлтүүлэг хийж, ноосны чанарыг сайжруулж байна



Зохиомол хээлтүүлэгт хамрагдсан хонины хээлтэй болон хөхүүл үе мөн шинээр төрсөн хурганы мэдээллийг Австралийн генетикийн мэдээллийн санд бүртгүүлсэн нь Монгол үүлдрийн хувьд анхдагч байсан



ноосны микрон 26-28 байснаас 2023 оны хээлтүүлгээс гарсан төлийн ноосны микрон 18-22 болж ноосны чанар сайжирсан үзүүлэлт гарсан



Мерино, Дохне Мерино удамшлын өндөр ач холбогдолтой гүн хөлдөөсөн үр болон хөврөлийг Австрали улсаас импортолсон



2024-2025 оны хооронд нийт 317 хурга гарсан бөгөөд 2026 онд илүү нэмэгдэх төлөвтэй байна



килограмм улаан буудайн хивэг болон эрдсийн шахмалыг зохиомол хээлтүүлэгт хонио хамруулсан өрхөд нийлүүлсэн



өрхийн болон аж ахуйн нэгжүүдийн хонио зохиомол хээлтүүлэгт хамруулах сонирхол нэмэгдэж 23 өрхөөс 29 өрх, 680 толгой хониноос 1,052 болж өссөн



2025 онд 3 сумын хэмжээнд хамрагдсан 680 хониноос 23 өрхийн хэмжээнд 45% Австралийн үрээр төллөсөн хурга хүлээн авч бойжуулсан

## Амжилтын түүх

Ганбаатар овогтой Гүндсамбуу миний бие 2015 онд ХААИС-МААБС-ыг мал зүйч мэргэжлээр төгссөн. 2019 оноос одоог хүртэл Малын удмын сангийн үндэсний төвд (МУСҮТ) мэргэжилтнээр ажиллаж байгаа. АДРА ОУБ, МААЭШХүрээлэнгийн хамтран нарийн, нарийвтар ноост Орхон, Хангай, Ерөө үүлдрийн хонины үүлдэрлэг байдал, ашиг шимийг нэмэгдүүлэх ноосны гарцыг сайжруулах зорилгоор 2022, 2023 онд Австрали улсын хоёр мэргэжилтэн багш биотехнологийн дэвшилтэд арга болох дурангийн аргаар хээлтүүлэг хийх, хөврөл шилжүүлэн суулгах онол, практикийн сургалтуудыг зохион байгуулж тус сургалтад би баг хамт олны хамт хамрагдсан. Тус сургалтаар дурангийн арга технологиор хөврөл шилжүүлэн суулгах, зохиомол хээлтүүлэг хийхэд биечлэн суралцсан нь ач холбогдолтой байсан. Цаашид манай байгууллага бие дааж дурангийн аргаар зохиомол хээлтүүлэг хийх чадвартай, хүний нөөцтэй болсон.

2024 онд МУСҮТ-ийн мэргэжилтнүүд бие даан Сэлэнгэ аймгийн 3 суманд нарийн, нарийвтар ноост 650 толгой хонинд дурангийн аргаар зохиомол хээлтүүлэг хийсэн. Эхний өдөр 80 толгой хонь, хоёр дахь өдрөөс 120 толгой хонинд хээлтүүлэг хийж гүйцэтгэлийн хувьд ур чадвар, хурд нэмэгдэж ахицтай байсан. Мөн уг онд 2 мэргэжилтэн, 6 оюутанд дурангийн аргаар хээлтүүлэг хийх арга технологийг танилцуулж биечлэн сургасан.

2025 онд мэргэжилтэн Т.Энхбилгүүнтэй хамтран Сэлэнгэ аймгийн 4 сум, Хэнтий аймгийн 1 суманд нийт 1258 толгой хонинд дурангийн аргаар зохиомол хээлтүүлэг хийсэн. Тухайн онд өдөрт 200 толгой хонинд хээлтүүлэг хийсэн. Дурангийн аргаар хээлтүүлэг хийхэд багаар ажиллах нь хамгийн чухал бөгөөд 8-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байвал хээлтүүлэг хийхэд үр дүнтэй, ажил хурдан шуурхай явагдана. Дурангийн аргаар хээлтүүлэг хийх нь уламжлалт аргаар хээлтүүлэг хийснээс хээл авалт өндөр байдаг учир малын чанар, үүлдэрлэг байдал богино хугацаанд нэмэгдэнэ. Ялангуяа Монгол улсад бий болгосон нарийн, нарийвтар ноост хонины үүлдэрүүдийг устаж үгүй болох эрсдэлээс сэргийлж Австрали улсаас 5230 тун гүн хөлдөөсөн үрийг манай улсад оруулж ирэн, бидэнд дурангийн зохиомол хээлтүүлгийн тоног төхөөрөмжийг өгч хэрхэн бог малд дурангийн хээлтүүлэг хийх чадвар суулгасан АДРА Монгол ОУБ-д талархаж явдгаа илэрхийлмээр байна. Бидэнтэй хамтран ажиллаж малынхаа ашиг шим, үүлдэр угсааг сайжруулахаар зорин ажиллаж байгаа малчдын оролцоо, хувь нэмрийг бас хэлэх нь зүйтэй байх. Монголд үржүүлж байгаа нарийн, нарийвтар ноост хонины үүлдрийг сайжруулах чиглэлээр 2022 оноос хэрэгжсэн энэ үйл ажиллагаанд орон нутгийн удирдлагууд малчид, мэргэжилтнүүд болон төслийн хамтын ажиллагаа шингэсэн гэж би боддог.





## Дэм дэмэндээ төсөл

### Төслийн мэдээлэл

Хугацаа	2026 оны 10 сараас 11 сарын хооронд
Зорилтот бүс	Хан-Уул дүүргийн 12-р хорооны 10-р сургууль
Зорилтот бүлэг	Өрх толгойлсон эцэг, эхийн 118 хүүхэд
Нийт төсөв	2,285.00 ам.доллар

Төслийг АДРА Монгол дахь ажилчид, тэдний гэр бүл, хувь хүмүүс болон Улаанбаатар дахь ОУ-ын сүм санхүүжүүлэв.

АДРА Монгол ОУБ-аас жил бүр зохион байгуулдаг Дэм дэмэндээ төсөл нь Улаанбаатар хотын амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхүүдэд хүнсний тусламжийн багц болон 6-16 насны хүүхдүүдэд өвлийн дулаан гутал олгодог. Энэхүү төслийг нийгэм дэх дэмжлэг шаардлагатай иргэдэд туслах, хүрч ажиллахын тулд санаачилсан юм. 2021 оноос эхэлсэн энэ төсөл нь нэгэнтээ Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх болон Сонгинохайрхан дүүргүүдийн зарим хороодод хэрэгжсэн.

Хандивын QR код:



2025 онд бид Хан-Уул дүүргийн 12-р хороонд байрлах Морингийн даваа хогийн цэгийн ойролцоох Нийслэлийн ерөнхий боловсролын 10-р сургуулийг сонгон ажилласан. Тус сургуульд 1,000 гаруй хүүхэд суралцдаг бөгөөд тэдгээрийн 60% нь эмзэг бүлгийн өрхөд харьяалагддаг.

Төслийн хүрээнд, АДРА Монгол ОУБ-ын ажилчид, сургуулийн захирал А. Туяасайхан болон багш, ажилчид мөн Улаанбаатар дахь ОУ-ын сүмийн төлөөлөл нар биечлэн оролцож 100 сурагчдад мөн Сөөхий гутлын дэлгүүрийн хамт олноос хандивласан 18 гутал буюу нийт 118 өвлийн гутал амжилттай тарааж өгсөн.

### Гол амжилтууд




- 118 хүүхэд өвлийн гуталтай болсон
- Төсвийн 95.2% нь зөвхөн гутал авахад зориулагдсан
- Нэг өдөрт амжилттай тарааж дууссан
- Сайн дурынхны идэвхтэй оролцоо
- Сурагчдын дэлгэрэнгүй бүртгэл дууссан



# Санхүүгийн тайлан

Хэлтэс/Төслүүд	Нийт төсөв (ам.доллар)	Зардал (төгрөг)	Зардал (ам.доллар)
Захиргаа	\$113,498.00	₮364,170,765	\$102,391
Органик хөдөө аж ахуйн түншлэл-2 төсөл	\$1,852,830.60	₮1,704,177,982	\$520,356.64
Халдварт бус өвчнөөс сэргийлэх төсөл	\$510,000.00	₮557,375,712.64	\$163,453
Эрс тэс уур амьсгалд нийцсэн газар тариалан төсөл	\$340,000.00	₮310,847,710.64	\$88,938.57
Нарийн, нарийвтар ноост хонь үржүүлгийн төсөл - 2	\$61,050.00	₮206,195,644.49	\$62,197.95
Нарийн, нарийвтар ноост хонь үржүүлгийн төсөл- 3	\$39,600.00	₮146,097,000	\$40,970.55
Дэм дэмэндээ төсөл	\$2,285.00	₮8,430,000	\$2,364
<b>Нийт</b>	<b>\$2,919,263.60</b>	<b>₮3,297,294,814.8</b>	<b>\$980,671.71</b>

# Санхүүжүүлэгч болон хамтрагч байгууллагууд



## Хүнсний аюулгүй байдал

Органик хөдөө аж ахуйн түншлэл-2 төсөл, Эрс тэс уур амьсгалд нийцсэн газар тариалан төсөл

## Эрүүл мэнд, шим тэжээл

Халдварт бус өвчнөөс сэргийлэх төсөл

## Амьжиргаа

Нарийн, нарийвтар ноост хонь үржүүлгийн төсөл

## Нөлөөлөл

Дэм дэмэндээ төсөл

## Захиргаа